

## “ТАТВАР ТӨЛӨГЧИЙН ӨДРҮҮД- 2024 ” ТАЙЛАН

2024 оны 05 дугаар сарын 16

Сайнцагаан сум

Татварын ерөнхий газрын Татвар төлөгчид үйлчлэх газраас ирүүлсэн “Татвар төлөгчдийн өдрүүдийг” тэмдэглэн өнгөрүүлэх ажлын тушаал, удирдамж, төлөвлөгөөний дагуу Татварын газрын даргын 2024 оны 04 дугаар сарын 12-ны өдрийн А/12 тушаалаар “Татвар төлөгчдийн өдрүүд”-ийг зохион байгуулах ажлын удирдамж, төлөвлөгөөг батлуулан бүх албан хаагчдад цахим хэлбэрээр хүргүүллээ. Татвар төлөгчдийн өдрүүдээр батлагдсан төлөвлөгөөний дагуу хариуцсан албан хаагч, тасгууд тухай бүр зохион байгуулан хийсэн сургалтын товч мэдээллээ Дундговь аймгийн татварын газрын цахим хуудсаар тухай бүр хүргэж ажиллалаа.





Энэ оны татвар төлөгчдийн өдрүүдийг угтан Аймгийн засаг даргын тамгын газартай хамтран Аймгийн засаг даргын тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсэг байгуулагдан Зах худалдааны төвд үйл ажиллагаа эрхэлж буй түрээслэгч иргэд болон хувиараа үйл ажиллагаа эрхлэгч иргэдийн “татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих”, татвар төлөгчдөд заавар зөвлөгөө өгч, хариуцлагатай татвар төлөгчдийг сурталчилах ажлыг зохион байгуулах "Бид хариуцлагатай татвар төлөгч-2" аяныг 04-р сарын 01-нээс 06-р сарын 28-ны өдрүүдэд зохион байгуулан ажиллаж байна.

### **Нэг. Татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих ажлын хүрээнд**

Татвар төлөгчийн өдрүүдийг угтан татварын хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Зах худалдааны төв үйл ажиллагаа эрхэлж буй түрээслэгч, хувиараа үйл ажиллагаа эрхэлж буй татвар төлөгчдийн Татварын ерөнхий хуулийн 28 дугаар

зүйлийн 28.5 дахь хэсэгт заасны дагуу тухай бүр төлбөрийн баримт олгодог эсэхэд хяналт тавьж, зөрчил илэрсэн 36 иргэнд татварын албаны шаардах хуудас, мэдэгдэл хүргүүлж, 2023 оны ХХОАТ-ын тайлан, татвар төлөлтөнд хяналт тавьж ажиллалаа.

- ✓ Худалдан авагч иргэдэд худалдан авалт бүртээ өөрийн и-баримт апплейкешинаар QR код уншуулан сугалааны дугаартай төлбөрийн баримтаа үүсгэн авах талаар видео контент бэлтгэн Аймгийн засаг даргын тамгын газар болон Татварын газрын цахим хуудсуудад байршуулан, олон нийтэд түгээн сурталчиллаа.





## Хоёр. Татвар төлөгч нарт хийсэн сургалт сурталчилгаа

### 2.1 Сошиал сувгаар хийсэн сурталчилгаа:



Дундговь аймгийн засаг даргын тамгын газар болон аймгийн татварын газрын цахим хуудсуудаар “Татвар төлөгчдийн өдрүүдийг” тэмдэглэн өнгөрүүлэх талаар татвар төлөгч нарт зориулсан мэндчилгээг татварын газрын дарга М.Туяацэцэг хүргэлээ.

Аймгийн шилдэг татвар төлөгчөөр шалгарсан 10 татвар төлөгчийн постерыг бэлтгэж татварын албаны цахим хуудсанд байршуулан сурталчиллаа. Шилдэг татвар төлөгчөөр:

- Б. Мөнхтуяа (бичил иргэн)
- У.Хүдэрчулуун (бичил иргэн)
- “СНЛ” ХХК (бичил сегмент)
- “Цэнгийн толь” ХХК (бичил сегмент)
- “Эрхэст-Ундарга” ХХК (жижиг сегмент)
- “САРУУЛ БАЯН УУЛ-АУДИТ” ХХК (жижиг сегмент)
- “МНЧ” ХХК (жижиг сегмент)
- “Номуун дэлгэрэх” ХХК (жижиг сегмент)
- “Дэлгэрэхийн баян залаат” ХХК (жижиг сегмент)
- “Бодьцогхангай” ХХК (жижиг сегмент) шалгарлаа.



2.2

## Сонин хэвлэлээр хийсэн сургалт сурталчилгаа, үйл явдлын мэдээ мэдээлэл

- Дундговийн амьдрал сонины 2024.05.06 ны өдрийн №11(381) дугаарыг татвар төлөгчдөд зориулан татварын хууль тогтоомж, мэдээ мэдээллийг нэгтгэн хэвлүүлсэн.
- Дундговийн амьдрал сонины 2024.05.13ны №12(382) дугаарт “Хариуцлагатай татвар төлөгч-2024” татвар төлөгчдийн өдрүүдийн сургалт хэлэлцүүлэгийн мэдээ мэдээлэлийг нийтлүүлсэн



## 2.3 Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад хийсэн сургалт

“Хариуцлагатай татвар төлөгч -2024” татвар төлөгчдийн өдрүүдээр ирээдүйн татвар төлөгч сурагч хүүхдүүдэд “Татвар хөгжлийн үндэс” сэдэвт сургалтыг ХШТ-ын ТУБ М.Мөнхбаяр, ЖТТХТ-ын ТУБ Э. Зулцэцэг нар Цэгцбилиг сургуулийн ахлах ангийн хөвгүүдийн бүлгэмийн 28 сурагч, Говийн ирээдүй цогцолбор сургууль, Мандал сургуулийн дунд ангийн 55 сурагчдад зохион байгууллаа





## 2.4 Сегментийн татвар төлөгчид хийсэн сургалт

“Хариуцлагатай татвар төлөгч-2024” татвар төлөгчдийн өдрүүдэд:

- “Эмийн сан, шүдний эмнэлэг, гоо сайхны эмнэлэг”-ийн үйл ажиллагаа эрхлэгч бичил, жижиг сегментийн татвар төлөгч нарт “Хяналт шалгалтын явцад гарч буй нийтлэг зөрчлүүд, анхаарах асуудал” сэдвээр ХШТ-ын ТУАБ Б.Жанчивдорж “Татвар хураах үйл ажиллагаа, татварын өрийн үлдэгдэл, анхаарах асуудал” сэдвээр БТТХТ-ын ТУАБ Н.Мөнгөнтуяа нар сургалтыг зохион байгууллаа. Тус сургалтанд эмийн сангийн үйл ажиллагаа явуулдаг 7, эмнэлгийн үйл ажиллагаа явуулдаг 11 нийт 18 хуулийн этгээд хамрагдлаа. (бичил сегмент 6, жижиг сегмент 12 татвар төлөгч)



- Шинээр байгуулагдан бүртгэгдсэн хуулийн этгээд, НӨАТ суутган төлөгчөөр бүртгэгдсэн хувь хүн, хуулийн этгээдэд “ААНОАТ-ын хөнгөлөлт, чөлөөлөлт, буцаан олголт” , “Татварын тайлан гаргалт”, “НӨАТ-ын тухай хууль” , цахим төлбөрийн баримт олголтын талаарх сургалтыг ХШТ-ын ТУБ М. Мөнхбаяр, БТТХТ-ын ТУБ Ж. Сугирмаа, ЖТТХТ-ын ТУБ Э. Зулцэцэг нар зохион байгууллаа. Тус сургалтанд 2024 онд шинээр байгуулагдсан бичил сегментийн 12 хуулийн этгээд, шинээр НӨАТ суутган төлөгчөөр бүртгэгдсэн 8 иргэн, 11 хуулийн этгээд нийт 31 татвар төлөгч хамрагдлаа.








- Аймгийн Худалдан авах ажиллагааны газар, татварын ХШТасаг, аймгийн ИТХ-тай хамтран олон нийтэд чиглэсэн авлигын эсрэг сургалтыг тендерт оролцдог жижиг сегментийн 12 татвар төлөгчдөд зохион байгууллаа.



- Зах худалдааны төвд үйл ажиллагаа эрхлэгч эмэгтэйчүүдэд ЖТТХТ-ын ТУБ Б.Ууганбат, ТУБ Ч.Долгоржав нар ХХОАТ-ын тухай хууль, НӨАТ-ын тухай хуулийн хэрэгжилт сэдвээр сургалтыг 13 татвар төлөгч эмэгтэйчүүдэд зохион байгууллаа.



Аймгийн СТСХ-тэй хамтран баялаг бүтээгч, бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаа татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ биелүүлэхэд дэмжлэг болох зорилгоор “Хариуцлагатай татвар төлөгч-2024” сургалт зөвлөгөөнийг зохион байгууллаа. Сургалт зөвлөгөөнд 15 сумын бизнес эрхлэгчдийн төлөөлөл 250 орчим татвар төлөгч оролцов.



Зөвлөгөөний үеэр Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Г.Энхтайван болон Татварын газрын дарга М.Туяацэцэг нар мэндчилгээ дэвшүүлэн, Дундговь аймаг дахь Хаан банкны салбарын захирал Д.Ганмягмар, Дундговь аймаг дахь Төрийн банкны салбарын захирал Э.Хөхөөхүү нар сургалт мэдээлэл хүргэлээ.





- Татварын мэргэшсэн зөвлөхийн нийгэмлэгтэй хамтран үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгч нарт “Татвар төлөгчийг татварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх” сургалтыг зохион байгууллаа. Сургалтыг ТМЗ, ММНБ, Гавъяат эдийн засагч Я. Батжаргал багш хийлээ.



“Хариуцлагатай татвар төлөгч-2024” сургалт зөвлөгөөнд 15 сумдын татвар төлөгчдийг хамрууллаа.





### Гурав. Татвар төлөгчдийн дунд зохион байгуулсан тэмцээн уралдаан

- Дундговь аймгаас 2024 оныг Хүүхэд гэр бүл хөгжил хамаагааллын жил болгон зарласантай холбогдуулан “Хариуцлагатай татвар төлөгч-2024” татвар төлөгчдийн өдрүүдийн хүрээнд бага насны хүүхдүүдийн дунд шатрын тэмцээн зохион байгууллаа. Тэмцээнд 4 -11 насны нийт 92 тамирчин оролцлоо.





- “Татвар хөгжлийн үндэс” - Гар зургийн уралдаанд бага ангийн насны ангилалд 83, дунд ангийн ангилалд 13, ахлах ангийн ангилалд 5 сурагч нийт 101 сурагч бүтээл ирүүлсэн.

Ирсэн бүтээлүүдээс бага насны ангилалд Б. Энхмаралын бүтээл, дунд насны ангилалд Ө. Цэлмүүний бүтээл, ахлах насны ангилалд Номин-Эрдэнэ, нийт 3 бүтээлийг шалгаруулан ТЕГ-ыг ТТҮГ-т хүргүүлсэн.



Мөн ирсэн бүтээлүүдээс гурван насны ангиллаар эхний 4н байр шалгаруулан, шалгарсан сурагчдын шагналыг гардууллаа.





Ахлан анги 1-р байр Говийн ирээдүй сургууль 10б Номин-Эрдэнэ, 2-р байр Говийн ирээдүй сургууль 10б Маралмаа, 3-р байр Мандал сургууль 11а Рэнчинжаргал нарын бүтээл шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагналаа.



Дунд анги 1-р байр Гурвансайхан сумын ЕБС-ийн 7а Цэлмүүн, 2-р байр Цэгцбилиг сургууль 9б Түвшинзаяа, 3-р байр Дэрэн сумын ЕБС-ийн 7а Ану-Үжин, тусгай байр Цэгцбилиг сургууль 6а Хулан нарын бүтээл шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагналаа.



Бага анги 1-р байр Мандал сургууль 3а Ж.Энхмарал, 2-р байр Эрдмийн далай цогцолбор сургууль 4в Б.Батжаргал, 3-р байр Хүмүүнлэг сургууль 3а Ц.Амгаланнинж, тусгай байр Эрдмийн далай цогцолбор сургууль 3а Саруулзаяа, Баянжаргал нарын бүтээл шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагналаа.





Гар зургийн уралдаанд анги хамт олноороо идэвхтэй оролцсон Эрдмийн далай цогцолбор сургуулийн 5в анги, 2а ангиудыг шагнаж урамшууллаа.



- Мандал сургуулийн ахлах ангийн 15 сурагчидад мэргэжил сонгохтой нь холбогдуулан татварын хэлтсийн үйл ажиллагаатай танилцах өдөрлөгийг зохион байгууллаа.





- "Хариуцлагатай татвар төлөгчид -2024" татвар төлөгчдийн өдрүүдийн нэгдсэн арга хэмжээний баярын үйл ажиллагааг Дундговь аймгийн Засаг даргын орлогч М.Анхбаяр нээж, аймгийн Засаг даргын тамгын газрын дарга Л.Доржбат аймгийн татвар төлөгчдөдөө мэндчилгээ дэвшүүлэн, сумдын бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжийн төлөөллийг аймгийн Засаг даргын Жуух бичиг, Хүндэт тэмдгээр шагналаа.





- "Хариуцлагатай татвар төлөгчид -2024" татвар төлөгчдийн өдрүүдийн нэгдсэн арга хэмжээний хүрээнд "Бид хариуцлагатай татвар төлөгч" бизнес эрхлэгч иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд танин мэдэхүйн асуулт, хариултын "Алтан хонх" тэмцээн, баг хамт олны нэгдэл, мэдрэмжийг шалгасан дартс, корнхол, орс таталтын нөхөрсөг тэмцээнийг Биеийн тамир, спортын газарт зохион байгууллаа.





Татварын хууль тогтоомжийн мэдлэгийг бататгах “Алтан хонх” тэмцээнд 13 сумын нийн 65 татвар төлөгч оролцож өөрийн авхаалж, мэдлэг оюунаараа бусдыгаа тэргүүлэн 1-р байр Луус сумын татвар төлөгч Цэвэгмид 2-р байр Адаацаг сумын татвар төлөгч Уранбилэг 3-р байр Адаацаг сумын татвар төлөгч Баасансүрэн нар шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнууллаа.



Дартс тэмцээнд 12 багийн 24 татвар төлөгч тамирчид оролцоноос

1-р байр Адаацаг сумын баг

2-р байр Өндөршил сумын баг

3-р байр Эрдэнэдалай сумын баг тамирчид тус тус шалгарлаа.



Корнхол тэмцээнд нийт 13 багийн 46 татвар төлөгч тамирчид оролцож

1-р байр Адаацаг сумын баг

2-р байр Өндөршил сумын баг

3-р байр Эрдэнэдалай сумын баг тус тус шалгарлаа.





Олс таталтын тэмцээний төрөлд 13 баг оролцсоноос

1-р байр Хулдсумын баг

2-р байр Өндөршил сумын баг

3-р байр Говь-Угтаал сумын баг тамирчид тус тус шалгарлаа



"Хариуцлагатай татвар төлөгч-2024" татвар төлөгчдийн өдрүүдийн нэгдсэн арга хэмжээнд оролцсон сумдуудыг нэгдсэн зөвлөгөөн болон баярын үйл ажиллагаанд оролцсон ирц, идэвх, багийн зохион байгуулалт, хувцаслалт, 4 төрөлт нөхөрсөг тэмцээний нийлбэр оноогоор дүгнэн шилдэг оролцогч сумдын баг хамт олныг шалгарууллаа. Үүнд:

1-р байр Эрдэнэдалай сум

2-р байр Хулд сум

3-р байр Өндөршил сум шалгарлаа.



Волейболын тэмцээнд нийт 18 оролцож хурд хүчээ сорьсоноос

1-р байр Өндөршил сумын баг

2-р байр Баянжаргалан сумын баг

3-р байр Эрдэнэдалай сумын баг тус тус шалгарлаа





Тэмцээнд оролцсон баг тамирчдын шагналыг Татварын газрын дарга М. Туяацэцэг, БТТХ тасгийн дарга Н.Мөнгөнтуяа, ЖТТХ тасгийн дарга Ч.Оюунжаргал нар гардуулан өгч цаашдын ажилд нь амжилт хүслээ.

### ДУНДГОВЬ АЙМГИЙН ТАТВАРЫН ГАЗАР